



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/101

Эг

Зорчих хэсгийг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Барх багийн нутаг Довын гарамд байрлах Бархын голын гүүр нь усархаг үргэлжилсэн бороо орсны улмаас голын ус үерлэж эвдрэл гарч хазайлт үүссэн тул 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 07 дугаар сарын 01-нийг хүртэлх хугацаанд гүүрээр зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр хориглосугай.

2. Захирамж гарсантай холбогдуулан нийт иргэд, сонгогчдод мэдээлэл хүргэж тухайн газарт анхааруулга, тэмдэг тэмдэглэгээг байршуулан хяналт тавьж ажиллахыг Барх багийн Засаг дарга (В.Чулуун), хэсгийн Төлөөлөгч ахлах дэслэгч (Р.Болор-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНСҮХ

232401263